

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ШУДАРГА ЁС, ИЛ ТОД  
БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2019.06.20

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Биелэлт
<b>1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний хүрээнд</b>			
1	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа доголдлыг бүртгэн мэдээлэх	Жилийн турш	Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/256 дугаар тушаалын дагуу ЭМГ, БОЭТ, Медипас төв эмнэлэг, Жаргалант сумын ЭМТ, 8 ӨЭМТ-ийн дэргэд нийт 2 салбар хороо, 1 хэсгийн хороо, эмнэлгийн мэргэжилтний 4 ёс зүйн баг байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.
2	Эмнэлгийн мэргэжилтэнд шударга ёс, ёс зүй, харилцаа хандлага, сонирхлын зөрчлийн талаар сургалт сурталчилгааны ажлыг салбар дунд үе шаттайгаар зохион байгуулах.	Жилдээ	Эрүүл мэндийн сайдын 2019 оны 01 сарын 21-ний өдрийн “Ёс зүйн сургалт зохион байгуулах тухай” А/19 дүгээр тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа, хандлагыг сайжруулах, ёс зүйн алдаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 18 сургалт зохион байгуулж, 678 эмнэлгийн ажилтан 186 үйлчлүүлэгч хамруулсан.
3	Эрүүл мэндийн салбар байгууллагуудын талаар холбоотой санал, гомдлыг хүлээн авч, бүртгэх, хурлаар хэлэлцүүлэн тухай бүрт нь шийдвэрлэх.	Жилдээ	Иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ. Ирсэн өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлт  2019 оны эхний хагас жилд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой нийт 56 санал, гомдол, талархал ирснийг 100% шийдвэрлэн ажилласан. Үүнээс хүсэлт 28, гомдол 18, талархал 10 байна. Эрүүл мэндийн газарт ирүүлсэн гомдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, ажиллагсдын харьцаа, хандлагатай холбоотой гомдол 50% өссөн үзүүлэлттэй байна. Үүний дагуу эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, талархал, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар байгууллагын болон салбарын өргөтгөсөн шуурхайд 7 хоног бүр тогтмол танилцуулж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагаанд Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсээс дотоод хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тайлан мэдээг хуулийн дагуу хугацаанд нь ЭМЯ, Аймгийн ЗДТГ-т гаргаж хүргүүлсэн байна. 2018 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.
<b>2. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хүрээнд</b>			
1	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах	Жилийн турш	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлж ажиллана.  2019 онд Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, бүртгэж хянаж хуулийн хугацаанд 5 албан хаагчдын материалыг явуулсан. Мөн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын 3 албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг Авлигатай Тэмцэх Газрын дүн шинжилгээний албанд санал

				<p>авахаар холбогдох материалиудыг хүргүүлж, санал ирүүлсэний үндсэн дээр томилгоо хийгдсэн.</p> <p>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэлийг дэвтэрт цаг тухайд нь хөтлөн ажиллаж байна. АТГ-ын ЭБАТ-ын эрхээр тайлангаа шивж хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн газрын 5 төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг аймгийн Засаг даргын захирамжийн дагуу нэмэгдүүлсэн. Үүнд: дөтгөөр зэрэг ахлах түшмэл -1, тэргүүн зэрэг дэс түшмэл-1, гутгаар зэрэг дэс түшмэл-1, дөтгөөр зэрэг дэс түшмэл-2 бөгөөд тус тус төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна.</p>
2	ЭМГ-ын албан хаагчдын үйлчилгээний стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллах.	II-III улиралд	Хяналт хийгдэж, стандартын хэрэгжилт хангагдана	<p>2019 онд Эрүүл мэндийн газарт шинээр ажилд орсон 2 албан хаагчдад “Албан хаагчийн үйлчилгээнд тавих шаардлага” CS61-0020-2015 стандартыг танилцуулан, мөрдөн ажиллахад хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн газрын албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулан цаг бүртгэх машинаар албан хаагчдын цаг ашиглалтыг хянаж, улирал бүр байгууллагын шуурхай дээр танилцуулан цаг ашиглалтыг сайжруулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.</p>
3	Төрийн албан хаагчийн нэрэмжит өдрийг ЭМГ-ын хэмжээнд зохион байгуулах /Хууль сурталчилах өдөр/	Улирал бүр	Төрийн албан хаагчдийн хуулийн мэдлэг дээшилнэ.	ЭМГ-ын албан хаагчдын дунд төрийн албаны шинэчилсэн хууль, авлигын эсрэг хуулийг сурталчилан таниулан улирал бүрийн сүүлийн сарын 7 хоногийн шуурхай зөвлөгөөн эхлэхийн өмнө албан хаагчдад 3 минутын хууль сурталчилах өдрийг зохион байгуулан ажиллаж хэвшсэн байна.
4	Төрийн албаны тухай шинэчлэл, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг сурталчлан таниулах арга хэмжээ зохион байгуулах.	II улиралд	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн эрхэмлэх ёсөн зүйлийг танин мэлсэн байна	<p>Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг Эрүүл мэндийн газрын албан хаагчдийн шуурхай зөвлөгөөнд нэг бүрчилэн төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмийг танилцуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчдийн саналыг үндэслэн Төрийн албаны ёс зүйн зөвлөлийг байгуулахаар санал авч ажиллаж байна.</p> <p>Төрийн бодлогын залгамж, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх үүднээс төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэж, нэр дэвшүүлсэн төрийн мэргэшсэн 1 албан хаагчийг Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэний дагуу ажлын байранд нь томилсон.</p>
	Төрийн захиргааны албан хаагчийн хуулийн мэдлэгийг дээшлүүлж, алба хаагчдын дунд АСТ буюу АХА тэмцээнийг зохион явуулах	IУлирал бүр	Хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ	Төрийн захиргааны албан хаагчдын дунд хуулийн мэдлэгийг дээшлүүлэн төрийн албаны шинэчилсэн хуулиар 12 албан хаагчдын дунд 03 дугаар сарын 26-нд АХА тэмцээнийг зохион байгуулан хуулийн мэдлэгийг дээшлүүлэн ажиллаж байна.
<b>3. Хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд</b>				
1	Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг	Жилийн турш	Төсвийн ил тод байдал хангагдаж, шилэн дансны	Шилэн дансны хуулийн хэрэгжилт, төсвийн ил тод байдлыг хангах үүднээс байгууллагын цахим веб хуудас болон шилэн

	мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх		хуулийн хэрэгжилт хангагдана	дансны нэгдсэн цахим системд төсвийн орлого, хандив тусламжийн орлого болон түүний зарцуулалтын тайлан мэдээг тухай бүрд нь байршуулан олон нийтэд ил тодоор мэдээллэж байна. Шилэн дансны мэдээлэлд хуульд заасан мэдээ тайлан, зарцуулалт, гүйцэтгэл, бусад холбогдох хавсралт материалыг PDF файлаар давхар хавсарган байршуулан ажиллаж байна. Байгууллагуудын ил тод байдал нэмэгдэнэ.
2	Эрүүл мэндийн үйлчилгээний шударга, ил, тод нээлттэй байдлын талаар хөндлөнгийн судалгааг хийж, мэдээлэх	III улиралд	ЭМБ-уудын ил тод байдал нэмэгдэнэ	Хийгдээгүй байна.
3	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, сонгон шалгаруулах	Жилийн турш	Хүний нөөцийн ил тод байдал хангагдана	Эрүүл мэндийн хөгжлийн төвд ЭМГ болон Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэн яаралтай шаардлагатай байгаа эмч, мэргэжилтнүүдийн нийт 19 ажлын байрны мэдээллийг илгээж цахим хуудсанд зар байршуулах, хүн хүчээр хангаж өгөх хүсэлтийг илгээсэн. Эрүүл мэндийн газар нь одоогийн байдлаар Эрүүл мэндийн сайдын 2014 оны 415 дугаар тушаал, Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтцийг Аймгийн засаг даргын 2018 оны 04 сарын 09-ны өдрийн А/197 дугаар захирамжийн дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 04 сарын 10-ний өдрийн Б/18 тушаалаар батлагдсан Удирдлага, төлөвлөлтийн хэлтэс, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн төв гэсэн 3 хэлтэс, 1 төвийн, 36 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. 2019 оны Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц үйл ажиллагааны чиглэлийг Аймгийн засаг даргын захирамжаар батлуулахаар захирамжийн төслийг Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлээд байна. Төрийн бодлогын залгамж, тогтвортой байдлыг хангаж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх үүднээс төрийн жинхэнэ албан хаагчийн 8 сул орон тоог “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгүүлсэн иргэдээс нэр дэвшүүлэхээр Орхон аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээд байна.

#### 4. Хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд

1	Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг мэдээлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах /дүгнэлт, зөвлөмж, шийдвэр г.м/	Жилийн турш	Хяналт, хариуцлагын тогтолцоо сайжирна.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар, МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/186 дугаар тушаалын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор ЭМГ-ын өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн байдалд 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр дотоод хяналтыг хийсэн. 2019 оны 05-р сарын 23-ны өдрийн байдлаар ЭМГ-т нийт 55 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн байна. <b>Илэрсэн зөрчил:</b> 1. Өргөдөл гомдлын хавтас file үүсгэсэн боловч баримталж буй хууль, тушаал шийдвэр байхгүй. 2. ЭМГ-ын өргөдөл гомдол шийдвэрлэх журам баталсан тушаал байхгүй. 3. Амаар гаргасан өргөдөл, гомдлыг тэмдэглэн авч,
---	---	-------------	---	---

				<p>бүртгэх тусгай бүртгэл байхгүй.</p> <ol style="list-style-type: none"> <li>4. Бичгээр ирсэн өргөдөл гомдолд бүртгэл хяналтын карт хөтлөгдөөгүй.</li> <li>5. Өргөдөл гомдлын мөрөөр судлах, тодруулах шалгалт хийх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч буй тодорхойгүй.</li> <li>6. Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн ТАХаагч шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын бүртгэлийн картыг зохих журмын дагуу бөглөн, хэлтсийн даргад танилцуулан гарын үсэг зуруулан, шийдвэрлэх явцад цуглуулсан баримт бичгийн хамт бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөх явц хэрэгждэггүй.</li> <li>7. 2019 оны 1-р улирлын өргөдөл гомдлын мэдээ тайланг хугацаандаа хүргэгдээгүй.</li> <li>8. Өргөдөл, гомдлын агуулга, бүтцийн судалгааг гарган, сар бүр байгууллагын дотоод сүлжээ болон цахим хуудсанд байрлуулан ил тод байдлыг ханган ажилладаггүй. Зөвхөн талархлыг face хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэдэг.</li> <li>9. Өргөдөл гомдлын мэдээллийн сан үүсэгдээгүй. Зөвхөн и-оффис программаар ирсэн өргөдөл гомдол мэдээлэл цахим хэлбэрээр хадгалагддаг.</li> </ol> <p><b><u>Санал:</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын хэмжээнд өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар /эрх зүй, заавар./ сургалт мэдээлэл хийх</li> <li>2. Бичиг хэргийн ажилтныг тушаал зааврын дагуу ажиллуулах</li> <li>3. Өргөдлийг хуульд заасан хугацаанд багтаан шийдвэрлэх асуудалд өргөдлийг хүлээн авсан хэлтэс, мэргэжилтэн нь анхаарал хандуулж, идэвхтэй ажиллах, хугацаанд нь өргөдөл, гомдлыг шийдвэрлээгүй албан тушаалтны ажлыг үнэлэхдээ тухайн асуудлыг харгалзан үзэж, үнэлгээнд оруулж тооцдог болох</li> <li>4. Хэлтсийн дарга дотоод хяналт тавин ажиллах</li> </ol> <p><b><u>Зөвлөмж:</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар хавтас, цахим мэдээллийн сан үүсгэх</li> <li>2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журмыг ЭМГ-ын даргын тушаалаар батлуулан ажиллах</li> <li>3. Амаар гаргасан өргөдөл, гомдлыг тэмдэглэн авч, бүртгэх тусгай бүртгэлийг бий болгох</li> <li>4. Өргөдөл гомдол бүр дээр бүртгэл хяналтын карт хөтлөх</li> <li>5. Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсэн ТАХаагч шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын бүртгэлийн картыг зохих журмын дагуу бөглөн, хэлтсийн даргад танилцуулан гарын үсэг зуруулан, шийдвэрлэх явцад</li> </ol>
--	--	--	--	---

				<p>цуглуулсан баримт бичгийн хамт бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөх явцыг хэвшүүлэх</p> <ol style="list-style-type: none"> <li>6. Өргөдөл гомдлын мэдээ тайланг нэгтгэн хугацаанд нь хүргүүлж байх</li> <li>7. Өргөдөл, гомдлын агуулга, бүтцийн судалгааг гарган, сар бүр байгууллагын дотоод сүлжээ болон цахим хуудсанд байрлуулан ил тод байдлыг ханган ажиллах</li> <li>8. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-д “Төрийн бүх байгууллага өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдэгдэнэ” гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах</li> </ol> <p>ЭМГ-ын даргын 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар ХШҮДА-ийн баг, тус багийн ажиллах журмыг шинэчлэн батласан. Үүний дагуу ХШҮДАБ хуралдан 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлуулан ажиллаж байна. 2019 оны НЭМТ, хэлтсүүдийн дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад ЭМГ-ын ХШҮДА-ийн багийн дарга Г.Энхжаргал, гишүүн Д.Отгондэлгэр нар 05 дугаар сарын 21-ний өдөр дотоод хяналт хийлээ. 2019 онд ЭМГ-ын хэлтэс, НЭМТ-ийн дотоод хяналтын төлөвлөгөөнд нийт 73 хяналт хийгдэхээр төлөвлөснөөс 1-р улиралд 18 хяналт хийгдэхээр төлөвлөсөн байна. Хэлтэс нэгжээр авч үзвэл:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Удирдлага төлөвлөлтийн хэлтэс-Бусад хэлтэстэй хамтран хийхээр 9 хяналт, дангаар мэргэжилтэн хийж гүйцэтгэхээр 3 хяналт, нийт 12 хяналт хийхээр төлөвлөсөн. Үүнээс 1-р улиралд хяналт төлөвлөгдөөгүй байна.</li> <li>2.Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс-Тайлант хугацаанд 9 төрлийн хяналтыг хийхээр тусгасан. Үүнээс улирал тутам хийгдэхээр 7 хяналт тусгагдсанаас 3 хяналт хийгдэж, 1 хяналт хэрэгжилтийн шатанд байна.</li> <li>3.Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс- Тайлант хугацаанд 34 хяналтыг төлөвлөсөн байна. Үүнээс 1-р улиралд 9 хяналт төлөвлөгдсөнөөс 5 хяналт хийгдсэн байна.</li> <li>4.Нийгмийн эрүүл мэндийн төв-Тайлант хугацаанд 21 хяналт хийгдэхээр төлөвлөснөөс 1-р улиралд 3 хяналт хийгдэхээр төлөвлөгдөн 100% хийгдсэн байна.</li> </ol> <p>2019 оны 1-р улиралд нийт төлөвлөгдсөн 18 хяналтаас 8 хяналт хийгдсэн, 10 хяналт огт хийгдээгүй, дутуу гүйцэтгэлтэй 1 /ӨОУ-ын ангилалын кодлолтод хийгдсэн хяналт/, төлөвлөгөөт бус хяналт 1 /Томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ/-ний чиглэлээр хийгдсэн байна.</p>
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон байгууллага дээр гэмт хэрэг гаргах нөхцөл үүсэхгүй байх тал дээр арга хэмжээ авч ажиллах.	Жилийн турш	Гадны аюул зөрчлөөс сэргийлнэ.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, эрчимжүүлэх чиглэлээр 2 зорилтын хүрээнд 7 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Байгууллага дээр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион

**БОЛОВСРУУЛСАН:** ЭДИЙН ЗАСАГЧ, ЭБАТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНДЭЛГЭР